



СУРЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ЖУРАМ

Шинэчилсэн: 2019 оны 6 сар

Дахин хянах: 2022 оны 6 сар

Шинэ Үе сургууль

2021

“Олон улсын баклавриат” гэдэг нэршлийг цаашид АйБи гэж товчилж буй. Энэ нь баклавын зэрэг биш хэдий ч баклавын суурь болох их сургуулийн бэлтгэл хөтөлбөр юм.

АйБи хөтөлбөрийн эрхэм зорилго

АйБи хөтөлбөр нь мэдлэг чадвартай, сонирхон судалдаг, хүн төрөлхтний өв уламжлал, ёс заншил, хэл соёлыг хүндлэн дээдэлж эх дэлхийн энх тайвныг эрхэмлэдэг, илүү сайхан ертөнцийг бүтээж чадах шинэ залуу үеийг бэлдэхийг эрхэм зорилгоо болгодог. Бид олон улсын байгууллага, засгийн газруудтай хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцсэн боловсролын хөтөлбөр боловсруулж, шударга, нягт шалгах үнэлгээний аргачлалыг улам бүр хөгжүүлсээр байна. Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд бүр идэвхтэй, хүсэл тэмүүлэлтэй, хүн бүрийн онцлог зан чанарыг ойлгон хүндэтгэж чаддаг, насан туршидаа сурч боловсрох чадвартай иргэн болон төлөвшдөг.

Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго

Бид шинэ үеийнхнийг

Халамжтай

Хариуцлагатай

Хүнлэг

Хичээнгүй

Эрүүл чийрэг

Эрдэм боловсролтой

Эх хэл өв уламжлалаа хайрлан хамгаалдаг

Энэ дэлхийн улс үндэстэн бүрийн ёс заншил ахуй соёлыг хүндлэн дээдлэх иргэн болгож төлөвшүүлнэ.

“Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

Эх дэлхийгээ энх тайван байлгаж, одоо байгаагаас нь илүү сайхан ертөнцийг бий болгохын тулд хүнлэг чанараа танин мэдэж, энэ дэлхий ертөнцийг хамгаалах хамтын үүргээ ухамсарлан ойлгох чадвартай олон улсын сэтгэлгээтэй хүмүүс болгон хөгжүүлэхэд “Ай Би” хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

“Ай Би ” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

ЭРЭЛХИЙЛЭГЧ Өөрсдийн сонирхсон зүйлсээ лавлан асуух, судлан шинжлэх чадвартай, аливаа зүйлд тэмүүлэлтэй, үргэлж суралцаж, хөгжих чадвартай иргэн болон төлөвшдөг.

МЭДЛЭГТЭЙ Тэд бүс нутагтаа болон олон улсад тулгамдсан асуудлын ойлголт, санаануудыг нээн олж чаддаг. Үүний үр дүнд тэрхүү ойлголт, санаа, асуудлынхаа талаар өргөн болоод тэнцвэртэй ойлголттой болж, гүн гүнзгий мэдлэг олж авч чаддаг. Олон талын мэдлэгтэй, түүнийгээ амьдралд хэрэглэх чадвартай иргэн болж төлөвшдөг.

ХЭРСҮҮ Нарийн төвөгтэй асуудлуудад дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй шийдвэр гаргахдаа шүүмжлэлт бүтээлч сэтгэлгээний чадварыг ашигладаг. Энэ нь тэднийг илүү хэрсүү ухаантай болгон хөгжүүлдэг.

ХАРИЛЦАГЧ Бусадтай илүү нээлттэй өөртөө итгэлтэй харилцаж, бусдыг ойлгож, анхааралтай сонсож тэдэнтэй хамтран ажиллах чадвартай иргэн болон төлөвшдөг.

ЗАРЧИМЧ Аливаа зүйлд зарчимч, шударга ханддаг, ёс зүйтэй, хууль дүрмийг чанд сахидаг, хүмүүсийн нэр төр ба эрхийг хүндэтгэж, өөрсдийн үйлдэл, тэдгээрийн үр дагавруудад хариуцлага хүлээж чаддаг иргэн болж төлөвшдөг.

НИЙТЭЧ Өөрсдийн соёл, бусдын үнэт зүйлс, уламжлалыг хүндэлж, бодитойгоор үнэлэн дүгнэдэг, юмсыг олон талаас нь харах чадвартай, туршлагаасаа суралцаж өсөн дэвжихэд бэлэн байдаг иргэдийг бэлддэг.

ХАЛАМЖТАЙ Өөрсдийгөө бусдын оронд тавьж, бусдыг энэрч, хүндэтгэдэг, бусдын амьдрал болон хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт авч ирж чаддаг иргэн болон төлөвшдөг.

ШИЙДЭМГИЙ Аливаа тодорхойгүй зүйлд шийдэмгий хандаж, шинэ шинэлэг санааг судлахын тулд бие даан болон хамтран ажиллах чадвартай, сорилт бэрхшээл, өөрчлөлтийн өмнө бэлэн зогсож чаддаг, хөрвөх чадвар сайтай иргэн болон төлөвшдөг.

ТЭНЦВЭРТЭЙ Өөрсдийн болон бусдын сайн сайхан зүйлсийн төлөө оюун ухаан, бие бялдар, болон сэтгэл хөдлөл зэрэг амьдралынхаа янз бүрийн төлөвийг тэнцвэржүүлэхийн чухал ач холбогдлыг ойлгодог, бусад хүмүүс болон амьдарч буй ертөнцтэйгөө харилцан хамааралтайгаа хүлээн зөвшөөрдөг уян хатан иргэн болон төлөвшдөг.

ЭРГЭЦҮҮЛЭГЧ Аливаа зүйлсийн мөн чанарыг эргэцүүлэн бодож, юмсын сайн муу, үнэн зөвийг ялган таньж ухаалгаар шийдвэрлэж чаддаг.

Агуулга

АйБи хөтөлбөрийн эрхэм зорилго	2
Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго	2
“Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар	3
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
ЖУРМЫН ЗОРИЛГО	5
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
ШУДАРГА БУС БАЙДАЛ (ЖУРМЫН ЗӨРЧИЛ)	6
СУРАГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	6
БАГШИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	7
СУРГУУЛИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	7
СУРЛАГЫН ШУДАРГА БУС БАЙДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЯВЦ	7
21 дүгээр зүйл: Сурлагын зөрчил гаргасан гэж сэжиглэсэн хэргийг мөрдөн шалгах	8
Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг	10
Дадал — сурагчдад өгөх зөвлөмж	10
Бусдын ажлыг ашиглах нь	10
Зайлшгүй байвал зохих зүйлс	11
ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ	11
Түгээмэл асуултууд	12
Ашигласан материалын жагсаалт	13

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Шинэ үе” сургууль нь сургалтын чанарыг сайжруулах, сурагчийн үндсэн ажлыг дэмжих ба боловсролын бүх түвшинд академийн ёс зүйгүй үйлдлийг багасгах үүднээс “Шинэ үе” сургуулийн “Сурагчдыг сурган хүмүүжүүлэхдээ өндөр хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилготой уялдуулан хичээл зааж буй багш нар үүнд чухал ач холбогдол өгч, сурагчдын ажлыг шалгах явцдаа энэ тал дээр анхаарч ажиллах хариуцлага гарч байгаа нь энэхүү журмыг боловсруулах үндэслэл болно.

ЖУРМЫН ЗОРИЛГО

Олон улсын боловсролын академийн ёс зүйг манай сургуульд хэвшүүлж, сурагчдын хийсэн ажил бүтээл нь тэдний өөрийнх нь, өөрийн бодож олсон санаан дээр суурилсан ажил байх ба бусдаас санаа авсан эсвэл иш татсан бол түүнийгээ үнэнчээр нийтэд мэдэгдэхийг уриалан дэмжих зорилгоор энэхүү журмыг боловсруулсан болно.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Шинэ үе сургууль (цаашид “ШҮС” гэх) нь хүн амьдралдаа юу ч хийсэн түүндээ үнэнч шударга байхыг эрхэмлэдэг. Шударга байх зарчим нь бидний “хариуцлагатай иргэн төлөвшүүлэх” эрхэм зорилготой шууд холбоотой бөгөөд сурагч бүрт суралцах үйл явцаар олсон мэдлэг чадвараа харуулах жигд боломж олгохын үндэс суурь болдог.

“International Baccalaureate (IB) буюу Олон улсын баклавриат хөтөлбөрүүд нь хүүхдүүдийг аливаа зүйлийн талаар асууж, шинэлэг, шүүмжлэлтэй байдлаар сэтгэн бодож, улмаар өөрийнхөө бодлыг аман болон илтгэх, үзүүлэн, загварчлал болон төрөл бүрийн бичгэн хэлбэрээр илэрхийлэх чадвартай болгодог. Гэтэл бид маш их мэдээлэл, бусдын санал бодлыг боловсруулах шаардлагатай үед амьдарч байна. Бид яаж хүүхдүүдийг өөртөө итгэлтэйгээр өөрийн суралцаж буй зүйлсийн талаар ярьж, бичиж, санаагаа яаж гаргаснаа боловсруулж, аль үзэлийг дагаж алинаас нь татгалзсанаа харах цогц чадвартай болгох вэ? Үүнд сургах арга нь шударга байх зарчим юм, өөрөөр хэлбэл, мэдлэг олж, түүнийгээ ойлгож, нээлттэй бодох явц юм”.

Шинэ үе сургууль сургалтын хөтөлбөртөө Олон улсын баклавриат байгууллагын дараах стандартуудыг баримталж, хэрэгжүүлдэг. Үүнд:

- Олон улсын бакалаврат хөтөлбөрийн хэрэгцээнд нийцсэн шударга байдлын журам болосвруулж, хэрэгжүүлдэг (IB Standard B1, Practice 5e).
- Сургууль нь Олон улсын бакалаврат хөтөлбөрийг дэмжих дүрэм, журам, үйл явц болосвруулж, хэрэгжүүлдэг (IB Standard B1, Practice 5).
- Сургах, суралцах үйл явц нь шударга байдлын журмыг баримтлахад нийцсэн ба түүнийг мөрдөг (IB Standard C3, Practice 4).

Шударга байх нь “зарчимч” байх гэсэн Олон улсын бакалавриат хөтөлбөрүүдийн хүүхдэд эзэмшүүлэхийг зорьдог сурагчийн 10 чадамжийн нэг хэсэг бөгөөд сурагчдыг

аливаа үйлдэл хийхдээ “үнэнч шударга” байхыг шаарддаг. (IB learner profile in review: Report and recommendation (April 2013), page 21).

ШУДАРГА БУС БАЙДАЛ (ЖУРМЫН ЗӨРЧИЛ)

Олон улсын бакалавриат байгууллага нь шалгуулах, үнэлүүлэх явцын үеэр бусдаас ямар нэгэн байдлаар (санамсаргүйгээр болон санаатайгаар) давуу нөхцөл байдлыг шударга бусаар олж авахыг зөрчилд тооцдог. Олон улсын баклавриат хөтөлбөрийн гориллогч бусад сурагчдад муугаар нөлөөлөх нь мөн зөрчилд тооцогдоно. Сурлагын зөрчил нь энэ журмыг зөрчсөн үйлдэл бөгөөд үүнд дараах зүйлийг авч үзэх боловч үүгээр хязгаарлагдахгүй:

бүтээлийн хулгай — бусдын санаа, ажил, бүтээлийг зохих ёсоор нь нийтэд мэдэгдэлгүйгээр (санаатайгаар болон санамсаргүйгээр) өөрийн мэт ойлголт өгөхүйц илэрхийлэх

нууцаар тохиролцох — нэгнийхээ шударга бус үйлдлийг дэмжих, өөрөөр хэлбэл, өөрийн эсвэл өөр нэгнийхээ ажлыг хуулбарлаж үнэлүүлэхийг зөвшөөрөх

шалгалтын үеэрх зөрчил — (жишээлбэл, зөвшөөрөөгүй материал шалгалт руу авч орох, бусад шалгуулагчдад саад учруулах, бусадтай шалгалтын үеэр ярилцах)

ёс зүйгүй үйлдэл — судалгаа хийх явцдаа оруулах ёсгүй, зүй бус зүйл оруулах, ёс зүйн журмыг зөрчих

горилогч шударга бус давуу талыг олж авах эсвэл өөр горилогчийн дүнд нөлөөлөх аливаа үйлдэл (жишээлбэл, шалгалтын өрөөнд зөвшөөрөлгүй материалыг оруулах, шалгалтын явцад зөрчил гаргах, CAS тэмдэглэлийг хуурамчаар үйлдэх, бичгээр шалгалт хийснээс хойш 24 цагийн дотор шалгалтын баримт бичгийн агуулгын талаар мэдээлэл өгөх, горилогчдоос мэдээлэл авах).

бүтээл хуулбарлах — нэг ажлыг дахин хуулбарлаж үнэлгээний өөр өөр хэсгүүдэд олшруулан өгөх, жишээлбэл, нэг хичээлийн бүтээлийг нөгөө хичээлд өгч үнэлүүлэх

(General regulations: Diploma Programme (Sep 2016), Article 20, page 12)

СУРАГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Сурагч нь багш, сургууль болон бусад гадны байгууллага руу илгээж буй бүх даалгавар ажлууд нь цэвэр өөрийн хийсэн байх тал дээр хариуцлага хүлээнэ.

- Бусдын бичсэн бүтээл, зураг, диаграм зэргийг шууд ашигласан тохиолдолд иш татах аргуудыг ашиглан эшлэлд оруулна.
- “MLA (Modern Language Association) буюу орчин үеийн хэлний холбооны хэв маягийг ашиглан судалгааны ажлуудад түлхүү ашигладаг эшлэлийн хэлбэрүүдийг ашиглана. Доорх линкээр дэлгэрэнгүй уншина уу.

Purdue Online Writing Lab (Purdue OWL) - <https://owl.english.purdue.edu>

- Бусдын санаа бодлыг ашигласан тохиолдолд тэр талаар нийтэд мэдэгдэж, зохих ёсоор хэрэглэж, энэ талаар тэмдэглэл хэсэгт оруулсан байна.
- Хүн бүрийн мэддэг мэдлэгийн талаар ямар нэгэн эшлэл хийх хэрэггүй.

Сургууль багаар ажиллахыг дэмждэг боловч багаар ажиллаж хамтын бүтээл хийсэн тохиолдолд энэ талаар мэдэгдэж, ил тод байлгах хэрэгтэй.

Суралцах үед шударга бус байдал үүсгэх гол шалтгаан нь бодох, судлах, бичих үйл явцуудад хангалттай хугацаа зарцуулж чадаагүйгээс үүсдэг. Иймд, аливаа ажил, даалгаврыг хийхдээ эртнээс төлөвлөж, хангалттай цаг зарцуулах хэрэгтэй.

БАГШИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- Бүх багш нар сурагчдын ажил өөрийнх нь хийсэн ажил мөн эсэхийг шалгаж, шударга байдлын журмыг мөрдүүлэх үүрэгтэй. Мөн сурагчдад гадны эх сурвалж ашиглах тал дээр нь зөвлөгөө өгч, зохих судлагаа хийх болон бичих чадварт сургах хэрэгтэй.
- Бусдын ажил бүтээлийг ашиглахдаа холбогдох стандартын дагуу хэрхэн иш татах болон ашигласан материалаа дурьдах ёстой талаар багш нар зөвлөгөө өгөх үүрэгтэй. Хэрэв багш энэ талаар хангалттай мэдлэггүй бол энэ талаар илүү мэдлэг туршлагатай багш болон номын санчтай хамтран сурагчдад хэрэгтэй мэдээллийг өгөх үүрэгтэй.
- Багш нар сурагчдын ямар ч хэлбэрээр багшид хүлээлгэн өгсөн ажлыг маш анхааралтай хянах үүрэгтэй. Хэрэв сурагчийн ажлын ихэнх хэсэг нь багшаас хараа хяналтаас хол хийгддэг бол багш сурагчидтай ойр ойрхон уулзах хэрэгтэй (жишээ нь дотоод үнэлгээний даалгавар эсвэл судалгааны эсээ).
- Багш нар сурагчдын ажил нь өөрийнх нь гэдгийг баталгаажуулахын тулд эцэг эхчүүдтэй хамтран ажиллана. Шударга байдлын журмыг зөрчсөн тохиолдолд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг багш нь эцэг эхчүүдэд ойлгуулах үүрэгтэй.

СУРГУУЛИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- Сургуулийн захиргаа нь багш, сурагчдад шударга байдлын журмыг баримтлах таатай орчин бүрдүүлж, үүрэг хариуцлагаа биелүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Сургууль нь багш нарт шударга байдлын журмыг мөрдүүлэхэд хэрэгтэй мэдлэг, чадварыг дээшлүүлэх боломжоор хангана.
- Сургуулийн захиргаа нь багш нартай хамтран эцэг эхчүүдэд энэ талаар ойлголт өгч тэдний оролцоог нэмэгдүүлнэ.

СУРЛАГЫН ШУДАРГА БУС БАЙДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЯВЦ

Аливаа сурлагын шударга бус байдлыг шийдвэрлэхдээ бүх талуудын нөхцөл байдлыг харгалзан үзэж, “өөрийн алдаанаас суралц” гэсэн үгийг баримтлан хамгийн үнэн шударгаар шийдвэрлэнэ. Өөр өөр асуудлуудад нэг шийдэл байдаггүй тул тухайн нөхцөл байдалд тохируулан шийдвэрлэнэ.

Сурлагын шударга бус байдлын зөрчлийг шийдвэрлэх хэд хэдэн ерөнхий алхам байдаг:

1. Хичээлийн багш тухайн зөрчлийг ангийн багшийн хамж мөрдөж эхэлнэ.
2. Багш сурагчид асуудлын талаар уулзалт хийнэ. Хэрэв сурагч ганцаараа ярихгүй эцэг эхийн хамт ярихыг хүсвэл эцэг эхийг нь дуудна.
3. Холбогдох тэнхимийн эрхлэгч, сургалтын менежерт мэдэгдэнэ.
4. Ангийн багш ба сургалтын менежер эцэг эхэд мэдэгдэж хамтын уулзалт хийнэ.
5. Сурагчийн хувийн хэрэгт тухайн зөрчлийн талаар болон авсан арга хэмжээг тэмдэглэнэ.
6. Шударга байдлын талаар ангийн багшийн, сургалтын менежерийн, номын санчийн хичээлээс гадуурх сургалтанд сууна.

Шударга бус байдал эсвэл зөрчил гаргасан тохиолдолд сурагчид нэмэлт арга хэмжээ (жишээ нь тухайн даалгавар, улирал, жилийн дүнг бууруулах) авч болно. Хэрэв зөрчил дахин давтагдах тохиолдолд сахилга батын арга хэмжээ (хичээлээс чөлөөлөх эсвэл сургуулиас бүр чөлөөлөх санал гаргах) авч болно.

Багш нар зөрчил давтагдах тохиолдолд дараах үе шатаар арга хэмжээ авна.

Эхний удаа: Даалгаврын дүнг бууруулах, дахин шалгалтанд орох, бие даалт болон бүтээлээ дахиж нөхөж хийх, шударга байдлын талаар хичээлээс гадуурх хичээлд суух

Хоёр дахь удаа: Улирлын дүнг бууруулах, сахилга батын захиа гэрт нь хүргүүлэх, сурагч-багш-эцэг эхийн гурвалсан гэрээ байгуулах

Гурав дахь удаа: Жилийн эцсийн дүнг бууруулах, хичээлээс түр чөлөөлөх

Дөрөв дэх удаа: Сургуулиас бүр чөлөөлөх хүсэлт гаргах.

21 дүгээр зүйл: Сурлагын зөрчил гаргасан гэж сэжиглэсэн хэргийг мөрдөн шалгах

21.1 Үнэлгээнд хамрагдахаас өмнө горилогчийн хийсэн ажлын үнэн зөв байдлын талаар асуулт гарч ирвэл тухайн нөхцөл байдлыг сургууль дотроо шийдвэрлэх ёстой. Хэрэв горилогчийн ажлыг АйБи-д үнэлүүлэхээр ирүүлсний дараа болзошгүй сурлагын зөрчил (жишээлбэл, хулгай, тохиролцоо) илэрсэн бол сургуулийн дипломын хөтөлбөрийн зохицуулагч аль болох богино хугацаанд АйБи-д мэдэгдэх ёстой.

21.2 Сургууль, шалгуулагч эсвэл АйБи нь горилогчийн сурлагын зөрчил гаргасан гэж сэжиглэх нотлох баримтыг тогтоовол тухайн сургууль мөрдөн байцаалт явуулж, АйБи-д хэргийн талаарх тайлбар, холбогдох бусад баримт бичгийг өгөх шаардлагатай болно. Хэрэв сургууль нь сурлагын зөрчилтэй холбоотой хяналт шалгалтыг дэмжихгүй бол тухайн хичээл дээр горилогчид үнэлгээ өгөхгүй.

21.3 Хэрэв АйБи нь горилогчийг сурлагын зөрчил гаргасан гэж сэжиглэж байгаа бөгөөд АйБи нь хянан шалгах ажиллагаа эхлүүлэх санаатай байгаа талаар тухайн сургуульд мэдэгдсэн бол сургуулийн захирлын үзэмжээр горилогчийг тухайн улирал болон тухайн зөрчил гаргасан хичээлээс хасагдахыг зөвшөөрнө. Гэсэн хэдий ч АйБи-ийн үзэмжээр горилогчийн сэжиглэгдсэн сурлагын зөрчилтэй холбоотой мөрдөн байцаалтын

ажиллагаа үргэлжлүүлэн явагдаж, сурлагын зөрчлийг нотлох эсвэл няцаах шийдвэрт хүрч болно. Хэрэв горилогчийг хичээлээс хассан бол тухайн хичээлд дүн өгөхгүй боловч энэ нь ирээдүйн шалгалтын үеэр дүн гаргахад нөлөөлөхгүй байх ёстой.

21.4 Сургуулийн дипломын хөтөлбөрийн зохицуулагч сургалтын зөрчил гаргасан гэж сэжиглэгдэж буй горилогчдоос сурлагын зөрчил гаргасан байж болзошгүй гэх сэжигтэй холбоотой гараар мэдүүлэг бичүүлж авах шаардлагатай. Хэрэв горилогч мэдүүлэг хийхээс татгалзвал горилогчийн дүрэм журам зөрчсөн эсэх талаарх хяналт шалгалт, шийдвэр үргэлжлүүлэн явагдана.

21.5 Сурлагын зөрчилд тооцогдох дийлэнх сэжигтэй тохиолдлыг Шалгалтын Комиссын дэд хороонд шалгуулна. Дэд хороонд ихэвчлэн АйБиБ-ын ажилтнууд, сургуулийн төлөөлөгчид, ахлах/орлогч шалгагч нар багтдаг боловч эдгээр хүмүүсийн аль ч бүлэг эсвэл нэгдэл нь Шалгалтын Комиссын зөвшөөрлөөр хэргийг шийдвэрлэж болно. Дэд хороог Шалгалтын Комиссын дарга, дэд дарга эсвэл дэд даргын санал болгосон ахлах шалгагч удирдана.

21.6 Дэд хорооны шийдвэрийг Шалгалтын Комиссын нэрийн өмнөөс болон түүний удирдлага дор гаргадаг. Мөрдөн байцаалтын явцад цуглуулсан бүх мэдүүлэг, нотлох баримтыг хянаж үзээд дэд хороо сурлагын зөрчлийн сэжигтэй тохиолдлыг хэрэгсэхгүй болгох, түүнийг хэвээр үлдээх эсвэл нэмэлт мөрдөн байцаалт явуулахыг эсэхийг шийднэ. Хэрэв дэд хороо шийдвэрт хүрч чадахгүй бол хэргийг Шалгалтын Комисст шилжүүлнэ.

21.7 Хэрэв дэд хороо сурлагын зөрчил гаргасан нь тогтоогдсон гэж үзвэл холбогдох хичээл(үүд)-д шийтгэл оногдуулна. Дэд хорооны шийдвэрийн дагуу шийтгэл нь сурлагыг зөрчлөөс үүдсэн хор хохиролын хэмжээтэй хувь тэнцүү байх болно.

21.8 Хэрэв горилогчийн АйБи дипломд нөлөөлөх хичээлээр дүн гаргаагүй бол горилогчид АйБи диплом олгохгүй. Дипломын хөтөлбөрийн хичээлийн дүнг сурлагын зөрчил гаргаагүй бусад хичээлээр олгох болно. Ноцтой буюу давтан зөрчил гаргасан тохиолдлоос бусад тохиолдолд, бүртгэлийн хугацаанд амжих бол, горилогчийг зургаан сарын дараа болох шалгалтуудад бүртгүүлэхийг зөвшөөрнө. АйБи дипломын горилогчийн хувьд, сурлагын зөрчил гаргасан үе нь горилогчийн АйБи диплом авах эрхийн гурав дахь шалгалтын үе бол дахин АйБи шалгалтуудад орохыг зөвшөөрөхгүй.

21.9 Хэрэв горилогч өмнөх шалгалтуудын үеэр дүрэм журам зөрчсөн нь тогтоогдож байсан бол ирээдүйн шалгалтуудад оролцох эрхээ хасуулахад хүргэнэ.

21.10 Горилогчийн дүн гарсны дараа, хэрэв бодит нотлох баримт байгаа бол АйБи нь сурлагын зөрчилтэй холбоотой хяналт шалгалт хийх эрхтэй. Хэрэв сурлагын ёс зүйгүй байдлыг Шалгалтын Комисс эсвэл дэд хороогоор хожим нь нотлогдсон бол тухайн зөрчил гаргасан хичээлээр үнэлсэн үнэлгээг горилогчоос хасч болох бөгөөд ингэснээр холбогдох АйБи дипломыг цуцлах болно.

Ерөнхий журам: Дипломын хөтөлбөр (2014 оны 4-р сар), хуудас 13

Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг

Дипломын хөтөлбөрийн сурагчийн хууль ёсны асран хамгаалагчийн хувьд бид хүүхдүүдээ хэрхэн дэмжлэг үзүүлж болох вэ?

- Даалгавар ажлуудыг төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлэх.
- Олон даалгавартай байж магадгүй тул далгавар хийх хуваарь гаргахад нь дэмжлэг үзүүлэх.
- Шаардлагыг ойлгохын тулд сургуультайгаа сайн харилцаа холбоо тогтоо Дипломын хөтөлбөр, оюутнуудаас юу хүлээж байгаа талаар.
- Сургуультайгаа байнгын харилцаа холбоотой байх, тэгснээрээ дипломын хөтөлбөрийн шаардлага болон сурагчдаас юу хүлээж байгааг ойлгоно.
- Даалгавар ажлаа гүйцэтгэхэд хүндрэлтэй байх тохиолдолд хичээлийн багшаасаа зөвлөгөө авч байхыг санал болгох.

Дадал — сурагчдад өгөх зөвлөмж

Текстийнхээ эх хэсэгт ашигласан мэдээллийг ном зүйд бүрэн оруулсан байх ёстой бөгөөд багшийнхаа зөвшөөрсөн эшлэлийн хэв маягийг ашигласан эсэхээ нягтлаж байх.

Эх сурвалжаа эшлэлд дурьдаж оруулснаар уншигчид тухайн мэдээллийн талаар илүү ихийг олох боломжтой болно. Хэрэв ашигласан материалынхаа эх сурвалжыг хэлж чадахгүй бол тухайн мэдээллийг ашиглахгүй байх.

АйБи нь сурлагын шудрага байдлыг зөрчсөн үйлдлийг санаатайгаар эсвэл санаандгүйгээр хийсэн эсэхийг мэдэх ямар ч боломжгүй тул сурагчид өөрсдийн биш материалыг хэрхэн дурьдах ба эшлэхийг мэддэг байх ёстой. Сурагчид шалгалтын өрөөнд болон шалгалтын үеэр баримтлах дэгийг дагаж мөрдөх ёстой.

Эдгээр шалтгааны улмаас, Дипломын хөтөлбөрийн Ерөнхий журмын батлагдсан зөрчлийг АйБи байгууллага шалгах тохиолдолд сурагчийн санаа бодлыг харгалзан үзэх боломжгүй юм.

АйБи хөтөлбөрийн дүрэм журмыг зөрчих нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Бусдын ажлыг ашиглах нь

Зөв ишлэл нь сурлагын ололт, оюуны сан хөмрөгийн гол хэсэг юм.

Илүү их заавар зөвлөмжийг АйБи байгууллагын вэбсайт дахь Дижитал хэрэгсэл хэсэгт байрлах *Үр дүнтэй ишлэл болон ашигласан материалын жагсаалт гаргах нь* гэсэн АйБи нийтлэлээс олж мэдэх боломжтой.

(<http://www.ibo.org/myib/digitaltoolkit/brochuresflyersposters/>)

Зайлшгүй байвал зохих зүйлс

- Аль үг, санаа, зураг, бүтээл нь (газрын зураг, график, хөгжмийн зохиол, кино, компьютерийн эх код болон бусад материалыг оруулаад) өөрийнх биш болохыг тодорхой бичих.
- Хуулбарласан, шинэчлэн өөрчилсөн, өөрийн үгээр орлуулан бичсэн материалыг мэдэгдэх.
- Текст ашиглахдаа ямарваа нэгэн эх сурвалжаас зөвшөөрөлтэйгөөр хэсэгчлэн авч ашигласан материалыг хаанаас эхэлж, хаана дуусгахыг тодорхой бичих.
- Текстэд дурдсан бүх эх сурвалжийг ном зүйд (эсвэл ашигласан материалын жагсаалт/иш татсан бүтээлийн жагсаалтад) жагсаасан байх ёстой бөгөөд ном зүйд орсон бүх эх сурвалжийг (эсвэл ашигласан материалын жагсаалт/иш татсан бүтээлийн жагсаалтад) текстэнд иш татсан байх ёстой.

ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ

Энэхүү журмыг хамгийн сүүлд хянан засварлаж өөрчилсөн өдрөөс хойшхи хоёр жил тутам дахин хянан өөрчилж байх болно. Хамгийн сүүлд энэхүү журмыг өөрчилсөн он, сар, өдөр уг журмын хуудас бүрийн баруун доод буланд тэмдэглээстэй байх ёстой.

Журамд оруулах аливаа өөрчлөлтийн талаарх санал санаачилгыг нийт багш нарын 70 хувиас доошгүй ирцтэй багш нарын хурлаар хэлэлцэн батлах ёстой. Багш нар тийнхүү журамд оруулахаар санал болгосон өөрчлөлтийг санал хураалтаар батална.

Тийнхүү баталсан засвар өөрчлөлтүүдийг сургуулийн захирал, сургалтын менежерүүд, хөтөлбөрийн зохицуулагч болон тэнхимүүдийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй сургуулийн захиргаа дахин хянан үзэж, бусад журам болон дотоодын хууль тогтоомжид үл харшлахаар байвал батална.

Журамд хамгийн сүүлд оруулсан аливаа засвар өөрчлөлт нь сургуулийн захиргаанаас өөрөөр шийдвэрлээгүй бол дараачийн хичээлийн жилээс эхлэн хүчин төгөлдөр болно.

Түгээмэл асуултууд

А: Бүгд хуурдаг биз дээ? - SUS үнэхээр анхаарал тавьдаг уу?

Х: Худал - бүгд хуурдаггүй. ШҮС-ийн сурагчид илүү ухаалаг, чадварлаг болж, өөрийн гэсэн ажлаа туурвих боломжтой болж байна. Мөн сурагчид АйБи дипломын хөтөлбөрт хамрагдахдаа ашигласан материалаа зөв жагсаан, иш татаж, талархал илэрхийлж сурдаг.

А. Сурлагын шударга бус байдал болон оюуны өмчийн хулгай нь ижил зүйл мөн үү?

Оюуны өмчийн хулгай хийх нь сурлагын шударга бус байдлын нэг хэлбэр юм. Оюуны өмчийн хулгай гэдэг нь гүйцэтгэсэн ажилдаа хэн нэгний үг, санааг ашигласнаа зохих ёсоор дурдахгүйгээр ашиглахыг хэлнэ.

А. Хэрэв би өмнө нь бичсэн даалгавраа өөр үнэлгээний даалгаварт дахин ашиглавал яагаад шударга бус гэж үздэг вэ?

Шинээр хийлгэж буй даалгавар бүр сурагчаас шинэ, өөр чадваруудыг шаарддаг тул өмнө нь ирүүлсэн даалгаврыг (эсвэл тухайн даалгаврын зарим хэсгийг) дахин ашиглах буюу 'дахин боловсруулах' нь сурлагын шударга бус байдлын нэг хэлбэр юм.

А: Бид яагаад иш татах ёстой вэ?

Х: Бид өөрсдийн мэдлэг, санаа бодлыг бий болгох, батлах үүднээс иш татдаг. Энэ нь уншигчдад бусдын бүтээлийг хүндэтгэхийн зэрэгцээ ашигласан материалын дагуу нэмж унших боломжийг олгодог.

Ашигласан материалын жагсаалт

1. AQA website: <http://www.aqa.org.uk/subjects/drama/a-level/drama-2240/why-choose> (last accessed August 2017)
2. Australian Psychological Society. <https://www.psychology.org.au/studentHQ/studying/> (last accessed August 2016)
3. Barden, Thomas E. Why Study Literature at All?
<http://www.poynette.k12.wi.us/faculty/sdobb/into.%20why%20study%20lit%2010.pdf> (last accessed August 2016)
4. International Baccalaureate Organization (2014). Programme Standards and Practices.
5. <https://www.ibo.org/globalassets/publications/become-an-ib-school/programme-standards-and-practices-en.pdf> (last accessed July 2018)
6. International Baccalaureate Organization (2016). General Regulations: Diploma Programme.
<https://www.ibo.org/globalassets/publications/become-an-ib-school/dp-general-regulations-sept-16-en.pdf> (last accessed July 2018)
7. Roopak, rtaneja00@gmail.com. Top Global University Ranking by Ib Requirements.
www.gotouniversity.com/universities-academics-requirements/ib.
8. Stamford University Department of Physics.
<https://physics.stanford.edu/undergraduate-program/why-study-physics> (last accessed August 2016)
9. Study in Holland: <https://www.studyinholland.nl/> (last accessed February 2018)
10. UCAS website: <https://www.ucas.com/> (last accessed February 2018)
11. Career advice. Retrieved March 11, 2021.
<https://www.indeed.com/career-advice/career-development/career-advice-for-college-students>
12. Mathematics Analysis and Approaches Guide 2021.
https://drive.google.com/file/d/1G_L_QtSu18X70rd08ulXaIKYD4Ux_IDW/view?usp=sharing
13. International Baccalaureate Organization (2021). Mathematics Analysis and Approaches Guide 2021. Retrieved March 11, 2021 from
https://drive.google.com/file/d/1G_L_QtSu18X70rd08ulXaIKYD4Ux_IDW/view?usp=sharing
14. Queensland Academy for Science Mathematics and Technology (2021). IBDP assessment guidance handbook 2021. Retrieved April 8, 2021.
15. International Baccalaureate Organization (2019). DP General Regulations. Retrieved April 8, 2021.

16. International Baccalaureate Organization (2017). DP Grade Descriptors. Retrieved April 8, 2021.
17. International Baccalaureate Organization (2015). DP: From principles into practice. Retrieved April 8, 2021.
18. International Baccalaureate Organization (2018). Diploma Programme Assessment Procedures. Retrieved April 8, 2021.
19. International Baccalaureate Organization (2010). Guidelines for developing a school assessment policy in the Diploma Programme. Retrieved April 8, 2021.
20. SUS IBDP Handbook 2021-2023. Retrieved May 5, 2021.
21. SUS Academic Misconduct 2018. Retrieved May 5, 2021.
22. IBO. Academic Honesty in the Diploma Programme. Retrieved May 6, 2021.
23. Get help. (n.d.). Retrieved May 06, 2021, from https://supra.net.au/cpt_helps/academic-honesty-frequently-asked-questions/
24. Garza, D. (2014, October 16). Academic honesty – principles to practice. Retrieved May 6, 2021, from <https://www.ibo.org/contentassets/71f2f66b529f48a8a61223070887373a/academic-honesty-principles-into-practice---celina-garza.pdf>
25. https://resources.ibo.org/data/g_0_malpr_sup_1408_2a_e.pdf
26. <https://www.ibo.org/globalassets/digital-toolkit/brochures/academic-honesty-ib-en.pdf>

СБД, 1-р хороо, Юнескогойн гудамж-12
Шинэ Үе сургууль, АйБи Оффис

АйБи дипломын хөтөлбөр
Сурлагын шудрага байдлын журам 2021-2023